

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:***

1-7

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:***

8-22

---

*1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

8

*2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

8-22

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны  
05 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Булгантуяа, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга Г.Гийхнаран,

мэргэжилтэн Д.Номингэрэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир 2023.04.25-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад дэмжигдсэн 30 зарчмын зөрүүтэй саналыг дахиж хураахгүйгээр хэвээр нь үлдээж, нэгдсэн хуралдаан дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналуудыг хураалгах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх:

“11.4.3.чанар ба үнийн хосолмол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 8  
Бүгд: 15

46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** 1.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх:

“11.4.3.чанар ба үнийн хосолмол.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.7, 11.8 дахь хэсэг нэмэх:

“11.7.Захиалагч энэ хуулийн 11.4.3-т заасан шалгуурыг хэрэглэх бол чанар ба үнийн шалгуур тус бүрд өгөх оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.8.Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсэг нэмэх:

“27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 8

Бүгд: 13

38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13  
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсэг нэмэх:

“27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “тэнцүү” гэсний өмнө “, эсхүл оноо” гэж, 27.16 дахь хэсгийн “өртөг” гэсний дараа “, чанар ба үнийн оноо тооцох” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг үйлдвэрлэгч, олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, С.Чинзориг, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.7 дахь заалт нэмэх:

“3.3.7.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн:

1 дүгээр зүйлийн “хэсгийн” гэсний дараа ““Шинжээчийг сонгохдоо” гэснийг “Шинжээчийн” гэж,” гэж, “өөрчилсүгэй” гэсний өмнө “тус тус” гэж, “тусгаж,” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “3” гэж өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, 7 дугаар санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2, 3 дугаар зүйлийг хасаж, 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

**“1 дүгээр зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “томилон” гэснийг “сонгон шалгаруулан” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.1.3 дахь заалт нэмэх:

“35.1.3.шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлж, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын “төрийн” гэсний дараа “орон нутгийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 11  
Бүгд: 13  
15.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 03 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 59 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА



## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 56 минут.

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Пүрэвдоржийн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ингээд миний бие гээд нийт 11 гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Байнгын хорооны тогтоолын төсөл буюу цаглавар батлах тухай асуудал байгаа. 2 дугаарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд гэсэн ийм 2 асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард**

*Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

1 дүгээр асуудал. Цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороо баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу 2023 оны 5 дугаар сарын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулттай гишүүд байна уу? Алга байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Цаглавар батлах тухай тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт хийх явуулъя. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүн дэмжжиг, 72.7 хувиар дэмжигдлээ. Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

10.57 цагт

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

2 дахь асуудалдаа орцгооё. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны

хэлэлцүүлгийг Улсын Их Хурлаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын даргаас Байнгын хороогоор тодорхой зарим зүйл заалтууд дээр дахиж хэлэлцүүлэх гэсэн чиглэлийг өгсөн. Үүнтэй холбогдуулж энэ асуудлыг дахиж хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ганболдын Гийхнаран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Даваадоржийн Номингэрэл Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 41.8-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийвэл хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзсэн. Ингээд энэ төслийг Байнгын хороонд буцааж ирүүлсэн байгаад байгаа. Ингээд буцаасантай холбогдуулаад хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүн, тэгье саналаа танилцуулъя та.

**Ц.Сандаг-Очир:** Дарга нэг горимын санал гаргая. Өмнө нь Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг дээр 30 санал зарчмын зөрүүтэй санал хураалгасан. Чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт буцаасан. Тэгээд 3, 4 санал дээр гүйцээн боловсруулалт чиглэл өгсөн. Ингээд ажлын хэсэг ажиллаад чиглэл өгсөн гүйцээн боловсруулах 8 саналыг

зарчмын зөрүүтэй саналыг бэлдэж оруулж ирсэн. Тэгэхээр өмнөх анхны хэлэлцүүлэг дээр Байнгын хороон дээр хураалгасан 30 зарчмын зөрүүтэй санал маань хөндөгдөөгүй учраас энэ удаагийн Байнгын хорооны хурал дээр энэ хөндөгдөөгүй 30 зарчмын зөрүүтэй санал дээр дахиж санал хураахгүйгээр шинээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн санал дээр зарчмын зөрүүтэй 8 саналын томъёоллыг оруулж ирж байгаа. Энэ 8 саналаа хураалгаад яв гэсэн ийм горимын санал оруулж байна. Энийг дэмжиж өгөөч.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Сандаг-Очир гишүүний гаргасан саналаар саяын горимын саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт. Саналаа өгье гишүүд. Санал хураалтад нийт 13 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжиж 69.2 хувиар Сандаг-Очир гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Ингээд ажлын хэсгээс оруулж ирж байгаа хуулийн төсөлтэй холбогдуулж оруулж ирсэн саналын томъёоллыг та бүхэнд нь уншъя. 8 саналыг ажлын хэсгээс гаргасан байна.

Нэгдүгээрх 1.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх:

“11.4.3.чанар ба үнийн хосолмол.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Асуулттай хүн байна уу? Асуулт, санал хураалтыг цуцалъя. Раднаасэд гишүүнд микрофон өгье асуулт асууна.

**Ш.Раднаасэд:** Өнгөрсөн Байнгын хороон дээр яриад унасан. Тэгээд Их Хурлаас даргаас чиглэл өгөөд бас засаад амьхандаа л болгож болгох гэж л оруулж ирж байна их баярлаж байна. Тэгээд яам бол тодорхой саналаа бол Чинзориг сайд өгсөн юм байна салбарынхаа.

Энэ харьцуулалтын үнэ ашиглалтын хугацааны өртөг гэдэг 2

дээр нэмээд чанар ба үнийн хосолмол гээд ингээд дахиад орж ирлээ. Тэгээд энэ дээр дахиад үнэ яригдах уу? Би нэг зүйлийг хэлье. Та бүхэн ажлын хэсэг тайлбарлаад байгаа юм Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм бол чанарын асуудал нь бүгд тодорхой гэсэн үг. Тийм учраас хямд үнийг нь авах нь гэдэг. Одоо энэ дээр чанар дээр нэмэх нь үнэ гээд. Би одоо хамгийн сүүлд авсан нэг юуг тендерийг л та бүхэнд хэлж өгье л дөө. Энэ эмнэлгүүдээс бас ганц нэг юмыг өөрийнхөө шугамаар олж авсан юм Зефиксим гээд энэ хүүхдийн л эм юм шиг байгаа юм. Энэ 100 миллиграммтай шахмал эм 30 ширхэгтэй. Энэ байна шүү дээ хамгийн хямдхан нь 14 мянга нийт 6 компани ороход, хамгийн үнэтэй нь 59 мянга, дунд нь ингээд 48 мянга, 55 мянга, 31 мянга гээд ингээд нэг эм улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн бүртгэлд бүртгэгдсэн нэг л эм. Энэ дээр чанар ижилхэн үү ижилхэн л гэж гарч ирнэ. Бид нар үнээ харна. Нөгөө хэмнэлттэй байх зарчмаа ярина шүү дээ гээд ингээд.

Тэгээд худалдан авах ажиллагааныхан болохоор энэ хуулийн амин сүнс нь зөв л дөө. Үнэхээр төсвийн мөнгийг гамтай хэмнэлттэй хэрэглэх зорилттой. Яг ийм эм, хүнс гэсэн ийм юман дээр чинь бид нар энэ ард түмэн чинь хүнсний шохой идэж байна шүү дээ. 14 мянган төгрөгөөр авсан тэр яг нэг эм чинь нөгөө үйлдвэрт нь нөгөө улсад нь 59 мянгаар орж ирдэг ямархуу чанартай юм байх вэ гэдэг нь бол ойлгомжтой. Ингэж 3, 4 дахин үнийн зөрүүтэй байна шүү дээ. Тэгээд энийг чинь хүн сар ууж байж зүгээр болж байхад нөгөө эмийг нь долоо хоног уух зүгээр болж байх жишээний. Яагаад энэ хүмүүс гаднаас энэ хүүхдийн эм антибиотикүүдыг энэ өөрсдийнхөө хэрэгцээтэй эмүүдийг явах боломжтой авах боломжтой хүмүүс нь гаднын улсуудаас очиж аваад байгаа юм гэдэг чинь чанарын асуудал байхгүй юу. Ялгаагүй л Монголд Монголд зардаг. Одоо энэ элэгний өвчлөл өвчлөлтэй хүмүүс бол бүгд энэ урсафалк гэдэг эм ууж байгаа. Элэг хамгаалах юм. Энд

зардаг эм Германд зардаг, Солонгост зардагасаа дахиад даруй 4 дахин хямдхан. Тэгээд эмч нар нь Монголоос болж өгвөл гаднаас аваад уугаарай гэж хэлж байгаа юм.

Тэгээд энэ чанар үнийн хосолмол гэдэг чинь дахиад л нөгөө үнээ бичээд бид нар оруулаад ирж байгаа байхгүй юу. Би энэ дээр энэ ялангуяа эм, эмнэлгийн хэрэгсэл дээр, эм дээр ядаж энэ хэмнэлттэй байна гэдэг юмыг ер нь боливол яадаг юм бэ? Бид нар энэ дээр улс зааж чадахгүй, үйлдвэр зааж чадахгүй, болдог бол улс заачихмаар байна л даа. Манай улсын эмийн стандарт гэдэг юм чинь өөрөө өөрсдөө тогтоочихсон ийм худлаа стандарттай болчихоод байгаа байхгүй юу. Тийм бусад улсууд шиг Солонгос ч гэдэг юм уу, Япон ч гэдэг юм уу, Сингапур ч гэдэг юм уу ингээд Америкийн эмийн стандартыг шууд авчихсан улсууд байна шүү дээ жишээлэх юм бол. Тэд нар бол айх ичих юмгүй явж байгаа байхгүй юу. Тэгээд эмийн компаниуд нь өөрөө энэ стандартын дагуу хийгдсэн гээд.

**Г.Тэмүүлэн:** Нэмэх юм уу. Тэгье. Асуултад ажлын хэсгээс хариулъя, 2 номер. Дараа нь Чинзориг сайд нэмж хариулъя.

**Ц.Батзул:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул. Өмнөх хурал дээр мөн чуулганы үеэр бас энэ асуултад хариулж байсан. Ер нь бид нар судалгаа хийж үзээд Монгол Улсын нийт зах зээл бол 650 тэрбум төгрөг байдаг юм байна. Үүнээс улсын төсвөөс санхүүжиж байгаа нь бол 220 орчим тэрбум төгрөг. Түүний 50 орчим тэрбум төгрөг нь зөвхөн эмд өгч байгаа юм байна гээд. Тэгэхээр нийт зах зээлийн маань юу гэдэг юм 1/13 нь энэ хуулийн дагуу явах юм. Тэгээд эмийг бол онцгойлон сая ажлын хэсэг дээрээ яриад Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу үнэ болон чанарыг нь харьцуулж үздэг болё. Тэгээд энэтэй холбоотойгоор шинэ үнэлгээний

шалгуурыг нь эм эмнэлгийн хэрэгсэл дээр тусгайлан хуулийн төсөлдөө оруулж ирсэн.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу Сангийн сайдын тушаалаар батлагдсан эм эмнэлгийн хэрэгсэл авахдаа чанар болон үнэлгээний харьцуулалтын аргаар авдаг хуулийн зохицуулалттай. Үүндээ бол бид 5 шалгуур үзүүлэлтийг авч үздэг. Нийт үнэ нь бага байх юм бол 70 оноо авдаг, үлдсэн 30 оноог нь бол чанарын үнэлгээнээс авдаг. Тэгээд нийлбэрээрээ өндөр оноотойг нь ялагчаар тодруулдаг ийм журамтай. Энэ 5 шалгуур нь болохоор 1 дүгээрт ДЭМБ урьдчилсан баталгаажуулалтад орсон бол 5 хүртэл оноо. Эм эмнэлгийн хэрэгсэл хатуу зохицуулалттай буюу SRA гэрчилгээтэй бол бас мөн 5 оноо. Тэгээд чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол 5 оноо. Тэгээд Англи, Америк, Европын фармакопейны шаардлага хангасан нотлох баримттай тийм ийм санал болгож байгаа бол мөн 5 оноо. Тэгээд өөрөө үйлдвэрлэдэг бол 5 оноо, тендерт оролцож өөрөө импортлодог бол тухайн багцынхаа харгалзах 5 оноогоо авдаг ийм зохицуулалттай.

Тэгээд ЭМЯ-ных нь холбогдох албан тушаалтнууд мөн Чинзориг сайдтай ярьж байгаад энийгээ бол пропорцыг нь өөрчилчихье 50, 50 юм уу эсвэл зөрүүлээд чанар нь 70 хувьтай байж болох юм гэдэг ийм зохицуулалтыг нь бас журмын түвшинд бол хийчих боломжтой юм. Үнийг бас харгалзах нь зөв юм. Нөгөө талдаа бид нарын ярьсан энэ Монгол Улсад байгаа эмийнхээ ерөнхий чанарыг бас дээшлүүлэх тал дээр хэд хэдэн шаардлагатай үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол бид нар чанаргүй дотроосоо үнэтэй авдаг болчих вий дээ гэсэн бас болгоомжлол байгаад байгаа юм. Тэгэхээр Монгол Улсад мөрдөгдөж байгаа бас энэ журам заавруудыг нь бас бүртгэлийнхээ тогтолцоог нь бас сайжруулах шаардлагатай юм байна

гэдэг дээр бол санал нэгдээд хуулийн төслийн 36.1.2 дээр бол бас ЭМЯ нь яам тухайн чанар олон улсын гадаадын стандартын шаардлага хангасан эм үйлдвэрлэгч болон ОУБ-аас нь бас эмийг нь нэгдсэн журмаар авах ийм зохицуулалтыг нь бол хуулийн төсөлдөө оруулж өгсөн байгаа. Хариулж дууслаа баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Чинзориг сайд нэмж хариулъя.

**С.Чинзориг:** Би гишүүдтэй санал нэг байгаа юм. Энэ эм гэдэг бол үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой асуудал стратегийн бүтээгдэхүүн. Тийм учраас энэ 30 жил бид энэ эмийн асуудалд бас төрийн хяналтгүй, зохицуулалтгүй, нөгөө талаасаа туслалцаа дэмжлэг байхгүй явж ирсэн байна гэж үзээд байгаа юм. Тийм учраас эм бол стратегийн бүтээгдэхүүн учраас бас төрийн оролцоо, хяналт, зохицуулалт бол байх ёстой гэж бол үзэж байгаа юм.

Одоогийн оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй санал дээр бол энэ чанар ба үнийн хосолмол аргыг ийм шалгуурыг ашиглана гэдгийг оруулж нэмж бол оруулж байгаа юм. Өмнөх хуульд ч бол байсан юм. Дан чанар гэхээр бол бас хэт бас нэг талыг барьсан өрөөсгөл болох асуудал гарна. Тийм учраас бол бид нар тэр чанар ба үнийн зохистой тэр харьцаагаар нь үнэлдэг байх, сая тэр хэн Батзул дарга яриад байгаа үнэн л дээ. Сангийн сайд энэ журмыг нь баталдаг. Одоо бол үнэ нь 70 үнийн нөлөөлөл 70 хувь, чанарын нөлөөлөл нь 30 хувь байна гэсэн ийм журам батлаад хэрэгжүүлээд. Энийг нь бид нар өөрчилье. 30 хувь нь үнэ, 70 хувь нь чанар байдаг юм уу ийм ч юугаар бол зохицуулъя гэж. Гэхдээ энэ бол нэлээн бага импортоор орж ирж байгаа эмийг чинь бол одоогийн байдлаар бол 1 тавхан хувь нь л 5 хувь нь л эднийхээр дамжаад энэ шалгуураар худалдан авчих юм байгаа юм.

Цаад 95 хувь нь бол нөгөө хувийнхан өөрсдөө оруулж ирж байгаа юм. Одоо бид нар нөгөө 36.1.2 дээр нэг давуу тал бий болгоё гээд гээд байгаа. Тэгээд олон улсын гадаад улс орны үйлдвэрлэгч болоод олон улсын байгууллагуудаас шууд худалдан авдаг эрхийг нь энэ хуулиар нээгээд өгчхөж байгаа юм. Тэгэхээр энэ бол нэлээн том бол эргэлт болно гэж бол бодож байгаа юм. Энэ НҮБ-ын хүүхдийн сангийн улс орнуудад эм худалдан авч нийлүүлдэг энэ том систем байдаг юм байна, 138 хооронд энэ системийг ашиглаж эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авдаг. Энэ системийг бид ашиглая гээд бол оруулчхаж байгаа учраас бол цаашдаа энэ чанар ба үнийн хосолмол энэ аргаар бид нар эднийхээр дамжуулахгүйгээр шууд тэр худалдан авах систем рүү орох боломж л нээгдчихэж байгаа юм.

Тийм учраас яах вэ энэ чанар ба үнийн хосолмол шалгуураар харгалзаж үзнэ гэдэг нь бол байж байг. Энэ бол нэг их буруутгахгүй болов уу гэж бол бодож байна. Зөвхөн чанар гэх юм бол тэгээд зөвхөн чанартай нэртэй бас хэт үнийн өндөр үнэтэй ийм бас эм рүү бас явах асуудал бас гарч магадгүй гэж бол болгоомжилж байгаа юм. Тийм учраас яах вэ энэ чанар ба үнийн хосолмол шалгуур хэрэглэнэ гэдэг нь байж байг. Нөгөө талдаа бид нар тэр 36.1.2 дээр НҮБ-ын хүүхдийн сангийн худалдан авах системийг ашиглаад шууд худалдан авч болно гээд нээгээд өгчхөж байгаа учраас бол энийгээ хэрэглэхгүйгээр тэр шууд худалдан авах арга руугаа нэлээн бас түлхүү ч явчих тийм боломж нь гарч байгаа учраас бол яах вэ энэ нь яах вэ хоёрдмол арга байж байг гэсэн ийм бол бодолтой бол байна.

Тэр Сангийн сайдын тушаалаар гаргаж байгаа журмаа нэлээн өөрчлөөд 70 хувь нь үнийн нөлөөлөл байдгийг нь өөрчлөөд, 30 хувь нь үнийн нөлөөлөл, 70 хувь нь чанарын нөлөөлөл байдаг байхаар тэр шалгуур үзүүлэлтүүдээ өөрчлөөд

журмыг нь нэлээн боловсронгуй болгоод гаргаад явчихъя гэдэг. Нийтдээ бол жилд нэг манайх нэг импортоор 430 орчим тэрбум төгрөгийн л тэрбум төгрөгийн борлуулалт хийж байгаа юм байна лээ эмийн. Тэнд түүний чинь 5 хувь нь л энэ энэ аргаар энэ өнгөрсөн жил 2 жил энэ Худалдан авах ажиллагааны газар явж байгаа их бага эзлэх эзлэх дүн нь бол бага юм байна гэж.

**Г.Тэмүүлэн:** Раднаасэд гишүүн тодруулъя.

**Ш.Раднаасэд:** Энэ 3 дахь шатлалын эмнэлгүүд чинь бол энэний зовлонг их сайн мэднэ дээ. Бид нар ингээд биччихдэг. Яг ижилхэн чанартай наадах чинь ингээд нэг лабораторийн бичигтэй олон улсад итгэмжлэгдсэн гээд нэг лабораторийн бичигтэй яг ижилхэн нэртэй ийм хямдхан үнэтэй эмийг чинь л аваад ирнэ. Яг ижилхнээр. Тэгээд энэнээс чинь болоод энэ хүмүүс эм нь үйлчлэхгүй болохоор өвс ургамал уугаад, энд тэндхийн амьтны элэг цөс юу байдаг юм ус рашаан хэрэгтэй байна гээд ингээд энэ амьд хүний амь хүний амь нас чинь энэ эмтэй чинь холбоотой яваад байна шүү дээ. Тэгээд одоо бид нар энэ дээр ингээд харин яриад тайлбарлаад ингэчихдэг энийг чинь бол энд бол их л гоё сонсогдож байна. Гараад яг хэрэглэнэ, тэр тендерт шалгаруулж байгаа комиссын нөхөд чинь болохоор эмнэлэг болгон дээр байгаа шүү дээ. Тэд нар чинь чанартай байна уу, чанартай байна. Ингээд л check list ишг юм бөглөөд л явж байгаа шүү дээ. Энэ дээр нь 5 оноо өгье, өгье. Яг ижилхэн нэртэй, ижилхэн чанартай, ижилхэн бүх үзүүлэлт нь.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Чинзориг сайд хариулъя.

**С.Чинзориг:** 14.3-д байгаа эхний 2 шалгуур бол эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад бол үйлчлэхгүй юм. Зөвхөн тэр 14.4.3-д оруулж байгаа чанар ба үнийн хосолмол гэдэг энэ шалгуур нь л бол эм эмнэлгийн хэрэгсэл худалдан

авахад бол үйлчлэхийн Раднаасэд гишүүн. Тийм учраас бид нар тэр Сангийн сайд журам гаргадаг. Тэр журамдаа бид нар тэр нөлөөллийнх нь харьцааг нь бол өөрчлөөд 30 хувь нь үнийн нөлөөлөл байна, 70 хувь нь чанарын нөлөөлөл байна гээд ингээд зохицуулчихаар бол энэ бол боломжтой болчихно.

2 дугаарт нь бид нар дараа нь санал хураана шүү дээ. Тэр 36.1.2-ыг хараарай та. Гадаад улс орны үйлдвэрлэгч болоод олон улсын байгууллагуудаас шууд худалдан авах эрхийг бол нээгээд өгчхөж байгаа юм. Тийм учраас бол бид нар цаашидаа энэ чанар ба үнийн хосолмол энэ шалгуурыг ашиглаж эм худалдан авахгүй. Үндсэндээ тэр шууд худалдан авах тогтолцоо руу үндсэндээ бол ороод явчихна. Тэгэхээр бол асуудал гарахгүй болов уу л гэж би цогц бодоод байна.

**Г.Тэмүүлэн:** Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

**Ш.Раднаасэд:** Хоёулаа ч еэвэнгийн 2 талыг яриад дуусах юм байна л даа. Ингэж болох уу Чинзориг сайдаа? Энэ шатлалын эмнэлгүүд чинь бүгд худалдан авалт хийж байгаа тийм ээ, өөрсдөө. Тухайн эмч нарынх нь хэдэн хувь нь ч гэдэг юм тэр юунд нь энэ эмийг нь авах нь зөв гэдэг ийм хэлбэрийг ямар нэгэн байдлаар оруулж болох уу? Тэр чинь өвчтөн дээрээ хэрэглээд энэ эм үйлчилдэг, үйлчилдэггүй юм байна лээ гэдгээ эд нар чинь мэддэг учраас эм өгөхдөө болдог бол та тэр улсаас аваадхаарай энэ эмийг. Энэ манайд зарж байгаа нь бас худлаа байлаа шүү гэж хэлээд байгаа шүү дээ аптект зарж байгаа нь. Тэгээд тэр чинь энэ эмийг аль улсад уусан эмийг нь үйлчилнэ хэнд хүндээр илүү үйлчилж байна гэдгээ тэр эмч нар чинь мэдээд байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг эмч нараас нь нэг асуулга хэлбэрээр авдаг ч юм уу ийм юмыг хийж болох уу? Арга ядсан л юм даа.

**Г.Тэмүүлэн:** Хариулах уу, хэн хариулах вэ? Чинзориг сайд.

**С.Чинзориг:** 2 ийм хүндрэлтэй юм бид нар гишүүдээс нуух юм байхгүй. 2 юм бид хийж чадахгүй байгаа юм байна лээ. Нэг дэх асуудал нь эмийн агентлагтай болсон. Гэхдээ энэ эм чинь Монголын зах зээл дээр худалдан борлуулагдаж байгаа бүх эмдээ чанарын хяналт баталгаажуулалт бүрэн хийж чадахгүй байна. Боловсон хүчний нөөц дутуу байна, тоног төхөөрөмжийн боломж нь бол алга байна.

2 дугаарт бидний хийж чадахгүй байгаа бас нэг юм бол энэ яг Раднаасэд гишүүний хэлээд байгаатай холбоотой. Энэ эм тариаг хэрэглэснээрээ тэр хүнд эмчилгээнд нь ямар тэр үйлчилгээ үзүүлж байна вэ гэдэг тэр үйлчилгээнийх нь тандалт хяналтыг бас бид бас бүрэн хийж чадахгүй байгаа юм. Ямар үйлчлэл үзүүлж байна гээд. Яг эмчилгээний үр дүн ямар болж байна гэдэг ийм чиглэлийн 2 чадавхтай болох асуудлыг бид бол хийгээд өгнө.

Цаашидаа бид нар энэ тэр шууд худалдан авалтын тогтолцоо руу ишлжисж байгаа учраас эмнэлгүүд өөрсдөө шууд худалддаг эм авах асуудал байхгүй болно. Агентлаг юм уу эсвэл яам юм уу тэр ЭМД-ын ерөнхий газар юм уу ямар нэгэн бүтцээр дамжуулаад бүх энэ эм улсын төрийн эмнэлгийн байгууллагууд мөн ЭМД-ын ерөнхий газар сангаас даатгалын сангаас олгодог хөнгөлөлттэй, чөлөөлөлт, хөнгөлөлттэй үнээр олгодог эмүүдийг нэгдсэн журмаар захиалга засаг өөрөө гаргаад тэр шууд худалдан авдаг тогтолцоо руу орчих юм. Тийм учраас бол эмнэлгүүд өөрсдөө шууд тендер зарла, тендерт оролцуулж эм авдаг энэ тогтолцоог бол бид нар халахын төлөө л энэ үйлдвэрлэгчээс болоод шууд ОУБ-аас шууд худалдан авдаг болгоно гэдэг ийм зохицуулалтыг хийгээд байгаа юм. Тийм учраас бол нэлээн энийг шийдээд өгчихвөл гишүүд минь энэ эмийн чанар, эмийн үнэтэй

холбоотой асуудал дээр маш том эргэлт, өөрчлөлт бас авчрах болов уу гэж би бол хэрдээ нэлээн найдаад, горьдоод бол байх юм.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт явуулъя. Санал хураалт, саналаа анхааралтай байгаарай гишүүд. Раднаасэд, Тогтохсүрэн. Санал хэн яах вэ, тэгчихлээ. Амартүвшин гишүүн санал гаргая.

**Г.Амартүвшин:** Саяын санал дээр санал хураалтдаа орж амжсангүй дахиж явуулна уу.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Амартүвшин гишүүний гаргасан саналаар саяын саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалт 75 хувиар дэмжигдсэн байна. Саяын санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахин явуулъя. Төслийн 11 дүгээр зүйл доор дурдсан агуулгатай 11.4.3 дахь заалт нэмэх.

11.4.3.Чанар ба үнийн хосолмол. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 76.9 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.7, 11.8 дахь хэсэг нэмэх:

“11.7.Захиалагч энэ хуулийн 11.4.3-т заасан шалгуурыг хэрэглэх бол чанар ба үнийн шалгуур тус бүрд өгөх оноог тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

11.8.Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Асуулттай хүн байна уу? Алга байна. Санал хураалт. 76.9 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсэг нэмэх:

“27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.” Асуулт байна. Одонтуяа гишүүн асуулт асууя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр яах вэ агуулгын хувьд бол дэмжиж байна бас энэ дээр чинь чанар харах ёстой, зөвхөн хямд үнэ биш гэдгийг бол ойлгож байна. Гэхдээ энэ хуульд нэг сайн гэдэг үг их орсон байх юм. Хуульд сайн, муу гэж үг үгүй ээ би бол их олон л хууль уншиж байна. Нэг их сайн, муу гэдэг үг хуульд нэг их тааралддаггүй. Энэ нь ингэ, тэгэхээр шаардлага хангасан гэж үзнэ гэдэг юм уу нэг энэ үгийг нь найруулахгүй бол энэ бүр энэ сайн гэдэг үг энэ хуульд бүүр маш олон байгаа байхгүй юу энэ жишээ нь. Тэгэхээр энийгээ нэг бодвол яасан юм бэ? Үгүй ээ, үгүй тэгэхээр зүгээр би бол юу мэдэхгүй, яах вэ тэгвэл цөөхөн хууль уншсан юм байлгүй. Тийм. Тэгэхээр сайн гэдэг үг бол зохимжгүй гэдэг саналаа хэлж байна.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсэг хариулах уу, ажлын хэсгийн ахлагч хариулах уу? 2 номер.

**Ц.Батзул:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул. Хуулийн төсөл дээр бол тендерт оролцсон компаниудын ирүүлсэн тендерүүдийг 3 шалгуураар ерөнхийд нь хянан үзэж байгаа. Эхнийх нь бол ерөнхий чадавх буюу тухайн оролцогч нь өөрөө эрх зүйн чадамжтай этгээд мөн үү, үгүй юү гээд. 2 дахь нь болохоор туршилага, техникийн үзүүлэлт, нөөц бололцоонд хүрэх эсэх. 3 дахь нь санхүүгийн чадавхтай эсэх. Энэ шаардлагуудын дараа санал болгож байгаа бараа, ажил, үйлчилгээнд бид нараас тавьсан стандарт норм хангавал зохих доод шалгуурыг хангаж байгаа эсэх дээр нь үнэлгээ хийгээд, энийгээ давсан компаниуд нь шаардлагад нийцсэн

гэж томъёологдож байгаа юм. Тэгээд тэр дотроосоо бид нар энэ дараагийн харьцуулах үнэ эсвэл чанар болон үнэлгээний хосолмол эсвэл ашиглалтын хугацааны өртгөөр нь ингээд 3 аргаар үнийг нь харьцуулж үзээд 1 дүгээрт эрэмбэлэгдэж байгаа компанийг нь Англи дээр нь бол *best be* гэж байгаа юм л даа. Тэгээд тэрийг нь бид нар тэр хамгийн давуу эрхээр нь, хамгийн сайн үнэлэгдсэн гээд одоогийн хуулийнхаа нэр томъёог нь л аваад явсан ийм зохицуулалт байгаа юм. Тэгэхээс биш бол шууд бага үнэ өгөнгүүт нь хамгийн сайн гэдэг ийм зохицуулалт бол байхгүй.

**Г.Тэмүүлэн:** Одонтуяа дарга.

**С.Одонтуяа:** Тийм, би бол энэ агуулгыг нь бол дэмжиж байна гээд байна шүү дээ. Би бол энэ ойлгочихсон. Гол нь зүгээр энэ Их Хурлын хуулийн ажлын албанаас би асуумаар байна л даа. Зөвлөхөөс сайн, муу гэж үг ер нь хуульд ингээд ороод байж болдог юм уу? Сайн тендер, сайн хүн юу гэх юм дараа нь нэг ийм хүнийг сайн хүн гэнэ гэх юм уу нэг энэ. Би үг дээр нь л хэлбэрийн хувьд яриад байгаа юм. Тэрнээс биш би агуулгыг нь бол дэмжиж байна. Энэ ЗГ-ын гээд аргачлал зааврын дагуу гээд тэрэнд. Тэгэхээр би энэ хуулийнхнаас л асуугаад байна л даа. Энэ референтээс.

**Г.Тэмүүлэн:** Эх барьсан зөвлөх хариулах уу? Энхсайхан сайн гэдэг. Тамгын газар хаана асаж байна вэ микрофон. Хууль зүйн талаас нь зөвлөх хариулах уу. 1 номер.

**Ё.Энхсайхан:** Энхсайхан зөвлөх Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Хамгийн сайн тендер гэж үнэлэх асуудал 2005 оны Тендерийн хууль дээр бол угаасаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа ийм нэр томъёо. Тэгээд хуулийн төслийн үзэл баримтлалд бас тусгагдсанаар нь нэгдсэн чуулганаас дэмжсэн учраас саналын томъёолол гараагүй учраас энэ нэр томъёогоор явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. Саяын энэ санал уналаа. Ажлын хэсгийн дарга өөрөө эсрэг өгсөн байна. Санал гаргах уу? Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны дарга миний энэ тоног төхөөрөмж бас эсрэг гараад байна. Уг нь дэмжиж өгч байгаа. Дахин санал хураалт явуулъя.

**Г.Тэмүүлэн:** Дахин санал хураалтыг явуулъя. Сандаг-Очир гишүүний саналаар. Санал хураалт. 53.8 хувиар дэмжигдлээ. Гишүүд анхааралтай санал хураалтад оролцоорой. Санал хураалтыг явуулъя. 3.Төслийн 27 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 27.6 дахь хэсгийг нэмэх.

27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний баталсан аргачлал зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ гэсэн. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт. Санал хураалт 53.8 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “тэнцүү” гэсний өмнө “, эсхүл оноо” гэж, 27.16 дахь хэсгийн “өртөг” гэсний дараа “, чанар ба үнийн оноо тооцох” гэж тус тус нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд анхааралтай Тогтохсүрэн гишүүн санал хураалт. 76.9 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хамгаалахтай холбоотой гэж унших юм байна тийм ээ. Найруулгын алдаа байна шүү. хамгаалахтай



холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт. Раднаасэд гишүүн, Чинзориг гишүүн, Батжаргал гишүүн. Раднаасэд гишүүн асуулт асууя.

**Ш.Раднаасэд:** Энэ 28-тай холбоотой асуулт энэ ЗГ өөрөө шийдэх юм уу? Хуулиар бид нар хийх ёстой юм уу? Яам өөрөө захиалагч, өөрөө тендер шалгаруулна, өөрөө хүлээж авна. Одоо энэ хэлбэр яг явах уу энэ хуулийнхаа дагуу. Яам нь захиална, яам нь хянана, яам нь хүлээж авна. Ер нь бүх тендер дээр. Энэ ганцхан эмийн асуудал биш, барилга байшин бүх юман дээр. Энэ 28 дугаар зүйл. Одоо уул нь энэ дээр яг өмнөх юун дээр бас юм орсон уу, үгүй юу? Энэ чинь нөгөө санхүү мөнгө, эрх мэдэл бүх хяналт чинь өөр дээр нь байгаа шүү дээ. Энийг нэг хариулж өгөөч. Асуулт юутай бол холбогдолгүй ч гэсэн.

2 дугаарт энэ дамжуулан авна гээд 36.1.2 дээр дамжуулан худалдан авна гээд тэгэхээр энэ дунд нь энэ бол вакцинтайгаа холбоотой гарч ирээд байна уу? Нөгөө ДЭМБ-аа хэлээд байх шиг байна тийм үү? Тэгж ойлгоод байна зөв үү? Үйлдвэрлэгчээс эсхүл ОУБ-аас шууд болон дамжуулан гэж. Тэгээд ДЭМБ-аа л хэлээд байх шиг байна л даа. Ийм 2 асуулт байна.

**Г.Тэмүүлэн:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг номер 2.

**Ц.Батзул:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 45 дугаар зүйл дээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах гээд тусдаа зохицуулалт орсон. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд заасны дагуу бол 2011 онд ЗГ-аас нэмэлт, өөрчлөлт өргөн бариад Их Хурлаас баталсан хуулиар бол Төрийн худалдан авах ажиллагааны газар улсын болон бүс

нутгийн чанартай худалдан авах ажиллагааг зохион байгуулна. Аймаг НЗД нь бол тухайн орон нутгийнхаа төсөл арга хэмжээний хувьд захиалагч нь буюу худалдан авах ажиллагааг зохион байгуулах. Үүнтэй холбоотойгоор аймаг, нийслэл дээр худалдан авах ажиллагааны нэгжүүдийг нь байгуулсан. Одоо энэ бүтэц маань хэвийн үргэлжлээд явж байгаа. Яамнууд бол цаашидаа тендер шалгаруулалт зохион байгуулахгүй.

Зөвхөн аж ахуйн буюу тухайн яамны өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлнэ. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүд бол ЗГ-аас жагсаалт батална. Жагсаалтаар хаана зохион байгуулахыг нь тодорхой зааж өгнө. Нэг бол төрийн худалдан авах ажиллагааны газар дээр зохион байгуулна үгүй бол орон нутгийн Засаг дарга нар луу шилжүүлдэг ийм тогтолцоо бол Монгол улсад мөрдөж байгаа. Энийгээ цааш нь хадгалаад явах юм.

Дамжуулан гэдэг асуудлын хувьд болохоор зарим үйлдвэрлэгч төвийн бол ОУБ өөрийн нэрлэсэн хүнээрээ бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг. Тэрийг нь бид нар дамжуулан гэж яг одоогийн хуулийн 34.1.7 дээр байгаа зохицуулалтыг нь аваад явж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Хариулт хангалттай юу? Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Би Раднаасэд гишүүний асуултад нэмээд хариулах тэр дамжуулан худалдах гэдэг бол байх ёстой байгаа юм. Одоо бид нар чинь ингээд хүүхдийн сангийн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авдаг тэр системийг ашиглана гээд шууд гээд оруулаад ирчхэж байгаа юм. Тэгэхээр манайх чинь энэ нөгөө сүрьеэтэй тэмцэхтэй холбоотой зардлыг чинь Глобал сангаар дамжуулаад 3 жилд нэг дунджаар 14 орчим сая долларын санхүүжилт Глобал

сангаас аваад сүрьеэ тэгээд нөгөө ДОХ, БЗХӨ-тэй тэмцэх чиглэлийн эм тариаг Глобал сангаас авдаг. Гэтэл Глобал сан маань нөгөө хүүхдийн сангаас энэ сангийн нөгөө системээр эмээ дамжуулаад бас аваад, тэгээд манайд бас өгдөг. Манайх тэндээс нь бас худалдаж авдаг тийм асуудлууд гараад байгаа юм. Тийм учраас бол энэ дамжуулан гэдэг нь бол байх хэрэгтэй болчхоод байгаа юм.

Би зүгээр 2 зүйл зүгээр редакц дээр хэлмээр байх юм. Тэр вакциныг үйлдвэрлэгчээс гэдгийн тэр үйлдвэрлэгчээс гээд ингээд орчихсон байна. Энийг гадаад улс орны үйлдвэрлэгчээс гээд редакцияар авчихгүй бол үйлдвэрлэгчээс гээд орчихоор дотоодын үйлдвэрлэгчдээс бас шууд худалдан авах юм шиг бас ингээд уншигдаад явчих болов уу гэж л нэг ийм асуудал. Энийг бас нэг редакц дээр нэг харж үзээч. Гадаад улс орны үйлдвэрлэгчээс гээд ингээд авчихвал. Тэр эсхүл гэдгээс би жоохон болгоомжлоод байгаа юм байна. Тэрийг уг нь авчихмаар байгаа юм. Тэгээд энэ Сангийн яам өчигдөр би одоо Сангийн яам, Худалдан ажиллагааны газрынхантай ярихаар эсхүл нь байж байг л гээд байгаа юм. Эсхүл үйлдвэрлэгчээс авч болно эсхүл ОУБ-аас авч болно гэхээр аль нэгээс нь л ав гэж хэлэх гээд байгаа юм биш биз дээ гээд би тэгээд байгаа юм.

Би бол аль алийг нь ашиглахыг хүсээд байгаа юм. Эсвэл үйлдвэрлэгчээс нь ав, эсхүл ОУБ-аас нь ав гэдэг ингээд аль нэгийг нь л ашиглах ёстой юм шиг юм уншигдаад байх юм гэхээр эд нар бол үгүй ээ болно, эсхүл гээд байж байхад бол аль алийг нь ашиглах тийм эрх нь нээгдэж байгаа юм гээд байгаа юм. Тэрийг бас нэг. Тэгэхээр хойд талд нь бас нэг болно гээд дахиад нэг юм орчихоод байгаа юм. Тийм учраас олон дахин болно гэж орчих гээд байгаа юм. Эсхүл л гэдгийг нь аваад үйлдвэрлэгчээс тэгээд таслал ОУБ-аас шууд гээд явж болох юм болов уу гээд. Тэгээд эд нарыг асууя. Тэгээд эд нар

дараагаар нь аль нэгийг нь ашиглах ёстой гээд ингээд бас та нар намайг бас мурьчих юм биш биз дээ? Би жаахан хардангуй л байгаад байгаа юм л даа.

**Г.Тэмүүлэн:** Чинзориг гишүүний асуултад хариулъя 2 номер.

**Ц.Батзул:** Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газар. Чинзориг гишүүнтэй бас саяын асуудлыг өчигдөр ярьсан юм. Тэгээд энэ дээр бас орж ирэхдээ томьёоллоо бас жоохон алдаатай оруулаад ирсэн юм байна. Тэгэхээр зарчмын хувьд бол зөрж байгаа зүйл бол байхгүй. Гадаадын үйлдвэрээс болон тэгээд ОУБ үйлдвэрлэгчээс нь зэрэг авахад бол татгалзах зүйл энэ дээр бол ямар нэгэн тийм зөрүүтэй зүйл бол байхгүй байгаа.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл саяын саналыг авъя гэж байгаа юм байна шүү дээ, Чинзориг сайдын саналыг. Тэгвэл ингэх юм байна шүү дээ. Био бэлдмэл вакциныг гадаад улс орны үйлдвэрлэгчээс гэж болох юм уу? Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир гишүүн. Тэгвэл энэ саналыг томьёоллыг нь бичиж байгаад та хэд дахиад оруулж ир. Эргээд хураалгая. Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** 2 зүйл байна. 1 дүгээрт үнэхээрийн энэ хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах үүднээс эмийн чанарын асуудлыг онцгой анхаарал хандуулж энэ асуудлыг дахиж авч үзэж байгаа. Тэгээд энэний эрхийг бид нар энэ санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эд нар луугаа энэ хуулиар үндсэндээ шилжүүлчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэнд хийхдээ тэр чанарын асуудал гэдэг юмаа онцгой бодож, тэр ямарваа нэгэн тэр өвчлөл элдэв бусын юмныхаа эсрэг дарангуйлах чадвар өндөртэй, хоруу чанар багатай, тэр эмчилгээний арга зүйдээ хамгийн их өндөр боломжийг бүрдүүлж байгаа тэр эм эмнэлгийн хэрэгслээ авдаг нөхцөлийг бүрдүүлсэн тийм журам заавруудыг

гаргах асуудлыг энэ Байнгын хорооны хурлын тэмдэглэлд зориуд суулгаж ийш нь чиглэлийг нь өгүүлэх ёстой. Тэгэхгүй бол өмнөх шигээ журам зааврууд гарчхаад, энд яригдаж хэлэгдсэн зүйлүүд ажил болохгүй болчих юм бол байдал хүндэрчихнэ. Тийм учраас үүнийг нэг зориуд хэлмээр байна гэж.

2 дугаарт тэр дамжуулан худалдан авах бол гэдэг үгээ та нар тодотгохгүй бол болохгүй байгаа юм. Үйлдвэрлэгчээс дамжуулан худалдан авдаггүй нэг ч байгууллага байхгүй яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр зэрэг тэр системийн үндсэн байгууллагуудаас нь авдаг тусгайлсан эрхтэй тэр Глобал сан энэ тэр гээд яриад байна. Тэгвэл тийм онцгой статустай байгууллагуудаасаа авч болох гэдэг үгээ тов тодорхой агуулгаар нь оруулахгүй бол энэ дамжуулан худалдан авах гэдэг үг чинь бол болж өгөхгүй байгаа юм. Онохгүй байгаад байгаа үг. Хэн ч эм авчирсан үйлдвэрлэгчээс дамжаад ирсэн л байж таараа шүү дээ. Тийм учраас наадах чинь ийм нэр ерөнхий нэр томъёоллоор орчих юм бол тэгээд тендер байхгүй бүгдийг нь юугаар авах бололцоо бүрдэнэ шүү. Хувь хүнээс ч болтугай эм авах бололцоо нөхцөл чинь эрх зүйн хувьд нээгдэнэ шүү. Тийм учраас энэ дамжуулан худалдан авах гэдгийнхээ өмнө тодотгол үгээ хийх ёстой. Үүнийгээ юу гэж ойлгож байна вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүний асуултад хариулъя 2 номер Батзул.

**Ц.Батзул:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ дээр нөгөө өчигдөр редакцын өөрчлөлт хийгээд олон улсын чанарын шаардлага хангасан эм эмнэлгийн хэрэгслийг нь үйлдвэрлэгчээс дамжуулан худалдан авч болно шууд болон дамжуулан гээд. Тэгээд энэ дээр нь уялдуулаад энэ худалдан авалтын журмыг нь ЗГ батлахаар заасан. Энэ

тохиолдолд бол бид нар энийг нарийвчлаад зохицуулчих боломжтой юм гэж харсан. Тэгээд өчигдөр бас ажлын хэсгийн хурал дээр энэ асуудал яригдаад, ОУБ-аас ер нь дамжуулан худалдаж авах шаардлага бол бодитой байдаг юм байна.

Хамгийн сүүлийн жишээ бол нөгөө Ковакс гээд вакциныг бас хөтөлбөрийн хүрээнд авсан. Үйлдвэрлэгчээс нь биш. Тэгэхээр яг энэ дамжуулан гэдэг үг бол бас зайлшгүй байх ёстой байгаад байгаа юм. Гэхдээ үгийн сонголт дээр бол сайн хэлж мэдэхгүй юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 34.1.7 дээр эм эмнэлгийн хэрэгслийг ОУБ-аас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол гэрээ шууд байгуулж болно гэдэг зохицуулалтыгаа тэр чигээр нь л аваад ороод ирсэн л юм байгаа юм л даа.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл энэ саналын томъёоллыг ажлын хэсэг шуурхай ажиллаад санал хураалтын эцэст нь хураалгачихъя. Энийг түр хойшлуулаад б дахь санал дээр орё. Томъёолол дээр нь ажиллая гэж байгаа юм. Ажлын хэсгийн дарга тэгвэл саналынхаа томъёоллыг унших уу? Сандаг-Очир гишүүн. Унших, Сандаг-Очир гишүүн саналаа уншъя эцсийн байдлаар томъёоллыг нь.

**Ц.Сандаг-Очир:** 36.1.2-ыг ярилцаж байгаад, ингэж байна. Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгч таслал тавиад ОУБ-аас шууд болон дамжуулан худалдан авах бол.

**Г.Тэмүүлэн:** Гэсэн саналын томъёоллоор санал хурааа. 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг саяын уншсанаар өөрчлөн найруулах санал хураалт. 61.5 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61.5 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.3.7 дахь заалт нэмэх:

“3.3.7.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа.” Санал гаргасан ажлын хэсэг. Нэг л уншигдахгүй болчхоод байна. Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч, томъёолол нь зөв үү аудитынхаа? 3.3.7.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагаа. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиа хэрэгжүүлээд түр хороо байгуулагдаад шинжээч татаад ажиллуулна энийгээ яах юм бэ гэсэн. Тэгээд өчигдөр нэлээн ярьж байгаад би нэг томъёолол орж ирэх юм байна гэсэн чинь орж ирсэнгүй шүү дээ. Энийгээ юу гэж ойлгох юм бэ? Энэ аудит дээр гараад байгаа зүйл биш. Ерөөсөө төрийн хяналт шалгалт дээр мэргэжлийн шинжээч татаж оролцуулах асуудлыг яаж шийдэх юм бэ гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу.

**Г.Тэмүүлэн:** 2 номер Батзул.

**Ц.Батзул:** Төрийн хянан шалгалт нь биш ээ Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн дагуу шинжээчийг томилох асуудал нь болохоор бид нар харахдаа хуулийн 35.1.1 дээр заасны дагуу гэрээ шууд байгуулаад явчих боломжтой гэж үзэж байгаа.

Урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын улмаас яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар гэрээ шууд байгуулах боломжтой юм гэдэг энэ авлагынхаа дагуу явчхаж болно гэж байгаа. Эсвэл аудитаас сонгосон шинжээчийг нь томилон ажиллуулах боломжтой бол гэж ярьсан байгаа.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт. 61.5 хувиар дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэн тул, дэмжигдсэнтэй холбогдуулаад Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн:

1 дүгээр зүйлийн “хэсгийн” гэсний дараа ““Шинжээчийг сонгохдоо” гэснийг “Шинжээчийн” гэж,” гэж, “өөрчилсүгэй” гэсний өмнө “тус тус” гэж, “тусгаж,” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг хүчингүй болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Энийг хураагдсан заалт юм байна. Тэгэхээр энийг хүчингүй болгох. Санал хураалт санал гаргасан ажлын хэсэг. 76.9 хувиар дэмжигдлээ.

2 дугаар зүйлтэй холбогдуулж. Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг хүчингүй болгох. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. 76.9 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбогдуулж. Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох. Санал хураалт. Санал хураалт 53.8 хувиар дэмжигдлээ.

4 дүгээр зүйлтэй холбогдуулж. Төслийн 4 дүгээр зүйлийн дугаарыг “3” гэж өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох. Санал хураалт. Одоо сүүлийн энэ 2 байна шүү дээ тийм ээ.

8.8 дугаар санал. 7 дугаар санал дэмжигдсэнтэй, эд нар чинь тийм ээ? 7 дугаар санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2, 3 дугаар зүйлийг хасаж, 4 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “томилон” гэснийг “сонгон шалгаруулан” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт. Раднаасэд гишүүн.

**Ш.Раднаасэд:** Энэ ялангуяа санхүүгийн гэмт хэрэг дээр энэ санхүүгийн дүгнэлт гаргуулахад шууд томилж байгаа. Одоо энэ чинь ингээд сонгон ер нь бол тэр дүгнэлтийг гаргахаас аль болохоор татгалздаг, зугтдаг. Энэ татвар дээр байх нь, аудитын байгууллагаас гарна. Тэгээд энэ дээр энэ томилдог хэсгийг нь нөгөө бүгдийг нь сонгон шалгаруулах юм болгочхов уу? Одоо нэг ямар нэгэн татварын ч юм уу, жишээ нь Оюу толгойн юуг ярьж л даа. Энэ дээр чинь шинжээч томилж байгаа шүү дээ. Түүнээс энийг чинь ингээд сонгон шалгаруулаад чамайг оруулна, чамайг оруулахгүй энэ чинь нэг төрлийн уралдаан шиг юм болгох гээд байна шүү дээ. Би орёе гэдэг. Тэгэх юм бол хэн ч очиж тэр юунд чинь оролцохгүй. Энэ яг бүх зүйл дээрээ байна уу эсвэл өөр юман дээр байна уу? Энэ 17.1-ийн надад нэг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч.

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариулъя. Хаанаас ажлын хэсгээс хэн хариулах вэ? 1 номер.

**Ц.Наранчимэг:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын тухай хууль 20 онд шинэчилсэн найруулгаар батлагдаж, бид Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.11 дэх заалтад бол төрийн аудитад шинжээч зөвлөх оролцуулахад энэ хуулийн зохицуулахгүй гэсэн ийм нэмэлт,

өөрчлөлт оруулж бид мөрдөж явж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн заалт бол төрийн аудит байгууллага аудит хийхдээ санхүүгийн тайлангийн аудитад Төрийн аудитын тухай 8.4-д заасны дагуу шинжээчийг авдаг. Сэдэвчилсэн болон Төсвийн байнгын хорооноос сэдвийг нь баталж өгсөн гүйцэтгэл нийцлийн аудитыг хийхэд тэнд шинжээч томилдог байгаа. Тэгэхээр санхүүгийн тайлангийн аудит маань өөрөө Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаатай. Цаглаварт хугацаанд хийхэд аудитын хуулийн этгээдүүдийг сонгон шалгаруулж, энүүгээрээ нээлттэй зарладаг.

Энэ хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор гадагшаа чиглэсэн журам баталж, энэ журмыг мөрдөж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ журмын хүрээнд бол бид нар энэ хуульд ийм заалт оруулснаараа богинохон хугацаанд шинжээчийг сонгон шалгаруулж ажиллуулах ийм боломжтой. Аудитын байгууллага өөрөө олон улсын стандартаараа хараат бусаар ажиллах ийм чиглэлтэй байгаа. Тэгэхээр энэний дагуу бол энэ шинжээчийг сонгон шалгаруулаад, хугацааны хувьд бол аудит аудитаа хийхэд ямар нэгэн хөндлөнгийн нөлөөлөл байхгүйгээр заасан хугацаанд аудитаа хийж, яг тэр шаардлага хангасан шинжээч зөвлөхийг сонгон шалгаруулах бүрэн боломжтой гэж үзсэн учраас энэ заалтыг оруулж ингэж өөрчлөлтийг оруулахаар санал хүргүүлсэн байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт. 53.8 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн саналыг хурааж дууслаа. Нямбаатар сайд зарчмын зөрүүтэй санал гаргана гэсэн. Нямбаатар сайдын микрофоныг өгье саналаа танилцуулна уу.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Төсвийн байнгын хорооны гишүүддээ хандаад хэлэхэд сая Улсын Их Хурлаас Шүүх шинжилгээний байгууллагын тухай хуулийг баталсан. Энэ Шүүх шинжилгээний байгууллагын тухай хуулийн 53 дугаар зүйлд байх. Шүүх шинжилгээний байгууллагын энэ урвалж бодистой холбоотой худалдан авах ажиллагааг зохицуулсан зохицуулалтыг хуульчилсан юм. Тэгэхээр би өнөөдөр энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-д өмнө нь Улсын Их Хурлаар батлагдсан шүүх шинжилгээний байгууллагынхаа хуультай уялдуулж дараах зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа юм.

Энэ нь шүүх шинжилгээний төв байгууллага нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодисыг үйлдвэрлэгчээс шууд болон дамжуулан худалдан авах эрхийг нээж өгөөч гэж. Энд би энэ гаргаж байгаа саналаа дэмжиж бас 2, 3 үг хэлэхгүй бол болохгүй байгаа юм. Жилд шүүх шинжилгээний байгууллага 400 орчим сая төгрөгийн урвалж бодисууд авдаг. Хими, биологи, бактериологийн шинжилгээ хийхэд шаардлагатай ийм урвалж бодисууд авдаг. Энэ нэг бодис биш 10 хэдэн төрлийн бодисуудыг авахаар энэ тухай бүрд нь 30 хэдэн сая төгрөгийн тендерийн ажлыг зохион байгуулахад ААН байгууллагууд энэ дээр оролцдоггүй.

Тэгээд үүнээс шалтгаалаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашилаад эрүүгийн болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шинжээчийн нарийн дүгнэлт шинжилгээ гаргахад бас асуудал үүсээд байгаа учраас энэ бага хэмжээний ийм бодис авахыг шууд үйлдвэрлэгчээс нь авдаг энэ эрхийг нээж өгөөч. Тэгвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд тухайн онд батлагдсан төсвийнхөө хүрээнд тухайн

онд төлөвлөсөн тэр бодисоо шууд худалдан авахаас ийм аргагүй нөхцөл байдал үүсээд байна.

Гэмт хэрэг зөрчил гэдэг бол ерөөсөө байнгын шинжилгээ хийх ийм шаардлагатай ийм харилцаа үүсэж байгаа. Өчигдөр шөнө гэхэд энэ баруун талын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хойд талын цэцэрлэгт нэг эрэгтэй нас барсан байх жишээтэй. Одоо энэ хүн дээр шүүх шинжилгээний байгууллага шинжилгээ хийхэд мөн ялгаа байхгүй энэ шинжилгээний нарийн урвалж бодисуудыг л шаардаад л дүгнэлтүүд гаргах шаардлага үүсдэг. Тийм учраас энэ гаргаж байгаа саналыг та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье.

**Г.Тэмүүлэн:** Нямбаатар сайдын гаргасан саналтай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Дахиад Нямбаатар сайд тодруулж хэлье, Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Энэ ийм байгаа юм 35 дугаар зүйлийн 35.1.3-д шүүх шинжилгээний байгууллагын нарийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал гэж унших юм байна лээ. Ингээж байж зарчмын санал нь зөв болно гээд референтүүд зөвлөж байна. Саналаа хураалгая.

**Г.Тэмүүлэн:** Энэ дээр Сангийн яам тайлбар тодруулга хэлэх зүйл байгаа юу? Энэ санал болгох Худалдан авах ажиллагааны газар 2 номер Батзул.

**Ц.Батзул:** Чуулганы үеэр, Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Би Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газар. Хуулийн төслийг боловсруулах явцад бол бид одоо яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 3 дугаар зүйл буюу үйлчлэх хүрээ бол анх батлагдахдаа 5 байсан. Ингээд шинэ хууль гарах болгондоо нэмэгдээд энэ 15 зүйл, заалттай болсон. Мөн гэрээ шууд байгуулах аргын дагуу худалдан

авахтай холбоотой зохицуулалтууд маань одоо ингээд анх 5 зүйлтэй байж байгаад одоо бол 12 зүйлтэй болчихсон. Ингээд шинэ хууль гарах болгонд ийм зохицуулалт нэмээд ингээд Худалдан авах ажиллагааны маань хуулийн хүрээ маань багасаад байгаа гэж үзсэн учраас бодлогын түвшинд аль болох улсын болон төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр авч байгаа бараануудыг нь энэ хуулийнхаа дагуу явуулах нь зүйтэй гэсэн зохицуулалтыг, ийм бодлогыг бариад энэ хуулийн төслөө тусгасан байгаа юм.

Хэрэв хууль шинжилгээний юу билээ, Шүүх шинжилгээний тухай хууль дээр нь тусгайлан тэгж заасан бол энийг нь. Тэгэхдээ бодлогын хувьд бол ингэж тусгайлан гарц гаргах нь буруу л гэж үзээд байгаа юм. Тэгээд гишүүд өөрсдөө шийдэх байлгүй дээ.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт. 53.8 хувиар дэмжигдлээ санал хураалт. Түр хүлээж байгаарай. Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэгээс зарчмын зөрүүтэй санал саналыг бас ирүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын “төрийн” гэсний дараа “орон нутгийн” гэж нэмэх гэсэн саналыг гаргасан байна. Гишүүний ирүүлсэн саналтай холбогдуулж санал хураалтыг явуулъя. Санал хураалт Гомпилдоогийн Мөнхцэцэг. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй. Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нэгдсэн хуралдаанд танилцуулна. Ингээд хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хаасныг мэдэгдье. Хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

11.59 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА